



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Бигэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/89/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Б.Нямдорж Утас: 99998436 Цахим хаяг: bnyamdorj5@gmail.com</p>	
---	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.28 № 149

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бигэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бигэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

07020255

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	54,715,766.59	75,576,006.72
33	АВЛАГА	868,620.28	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	868,620.28	-
33101	Цалингийн авлага	859,420.00	-
33102	НДШ-ийн авлага	9,200.28	-
35	БАРАА МАТЕРИАЛ	53,847,146.31	75,576,006.72
35100	Түүхий эд материал	51,507,146.31	61,728,681.72
35110	Тусгай зориулалттай материал	51,417,146.31	60,543,681.72
35130	Эм боох материал	90,000.00	1,185,000.00
35400	Хангамжийн материал	2,340,000.00	13,847,325.00
35420	Аж ахуйн материал	720,000.00	720,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,620,000.00	10,327,650.00
35460	Хүнсний материал	-	2,799,675.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	3,300,247,318.52	2,937,769,829.03
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,300,247,318.52	2,937,769,829.03
39200	Биет хөрөнгө	3,197,875,318.52	2,875,147,829.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,720,874,176.61	2,468,863,016.83
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(83,212,196.88)	(119,620,100.88)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(6,666,666.72)	(8,333,333.40)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	76,405,910.00	70,607,344.00
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(42,378,464.76)	(17,448,629.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	227,362,033.50	226,825,020.00
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(78,197,173.37)	(98,544,831.03)
39214	Бусад үндсэн хөрөнгө	371,478,673.00	371,478,673.00
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(7,325,022.86)	(46,115,256.98)
39217	Номын фонд	9,534,050.00	17,435,927.32
39300	Биет бус хөрөнгө	102,372,000.00	62,622,000.00
39301	Програм хангамж	1,117,500.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(967,500.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	102,222,000.00	62,322,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	3,354,963,085.11	3,013,345,835.75
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	0.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
41300	Өглөг	0.00	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	0.00
41312	НДШ-ийн өглөг	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	3,354,963,085.11	3,013,345,835.75
51	Засгийн газрын хувь оролцоо	3,354,963,085.11	3,013,345,835.75
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	511,201,648.27	511,201,648.27
51200	Хуримтлагдсан үр дүн	1,900,668,565.57	1,750,465,792.93
51210	Өмнөх үеийн үр дүн	1,900,668,565.57	2,092,083,042.29
51220	Тайлант үеийн үр дүн	-	(341,617,249.36)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	943,092,871.27	751,678,394.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	3,354,963,085.11	3,013,345,835.75

Говь-Алтай аймгийн Бигэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,131,571,241.00	939,695,029.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,192,162,357.00	60,852,344.73
1200	Нийтлэг татварын бус орлого	2,192,162,357.00	60,852,344.73
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,192,162,357.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,192,162,357.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	51,244,229.32
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	9,608,115.41
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	939,408,884.00	878,842,685.00
1310	Улсын төсвөөс	875,918,400.00	828,866,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	875,918,400.00	828,866,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,680,084.00	7,184,985.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	2,349,600.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	18,255,484.00	4,295,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	75,000.00	2,889,985.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,810,400.00	42,791,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,810,400.00	42,791,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,026,795,186.34	1,024,430,458.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,026,795,186.34	1,024,430,458.51
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	927,941,374.30	987,773,237.23
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	693,917,207.00	672,753,326.00
210101	Үндсэн цалин	590,514,615.00	578,030,606.00
210104	Урамшуулал	57,969,881.00	48,551,020.00
210105	Гэрээт ажлын цалин	45,432,711.00	46,171,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,131,759.15	89,435,737.22
210201	Тэтгэврийн даатгал	66,557,560.15	63,247,025.28
210202	Тэтгэмжийн даатгал	522,065.00	6,930,802.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,515,331.00	5,250,175.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,319,035.00	1,244,799.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,217,768.00	12,762,935.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,772,599.53	28,609,380.78
210301	Гэрэл, цахилгаан	2,269,349.53	2,170,180.78
210302	Түлш, халаалт	30,503,250.00	26,439,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,911,940.00	9,353,085.00
210401	Бичиг хэрэг	1,274,950.00	2,404,485.00
210402	Тээвэр, шатахуун	3,358,630.00	2,154,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	275,000.00	445,000.00
210404	Ном, хэвлэл	4,369,800.00	2,645,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	493,360.00	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,140,200.00	1,204,500.00
2105	Нормативт зардал	21,668,385.00	23,553,610.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,280,000.00	1,606,580.00
210502	Хоол, хүнс	19,038,385.00	20,747,030.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,350,000.00	1,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	720,000.00	2,469,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	720,000.00	720,000.00
210604	Урсгал засвар	-	1,749,700.00
2107	Томиллолт, зочны зардал	432,000.00	702,000.00
210702	Дотоод албан томиллолт	432,000.00	702,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	843,500.00	1,466,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,466,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	47,500.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,543,983.62	159,430,398.23
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	1,090,000.00	615,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	78,453,983.62	158,814,898.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,853,812.04	36,657,221.28
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,489,800.47	3,724,769.22
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,489,800.47	3,724,769.22
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,490,780.57	10,172,387.06
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,490,780.57	10,172,387.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,873,231.00	22,760,065.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,335,367.00	16,499,265.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	15,910,284.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,627,580.00	6,260,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	44,000.00	256,881,820.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=II)	2,104,776,054.66	(84,735,428.78)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	44,000.00	256,881,820.58
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	44,000.00	256,881,820.58
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	44,000.00	256,881,820.58
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	2,104,732,054.66	(341,617,249.36)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	НИЙТ ДҮН
1	ҮЛДЭГДЭЛ	-	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
8	ҮЛДЭГДЭЛ	511,201,648.27	943,092,871.27	1,900,668,565.57	-	3,354,963,085.11
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	191,414,476.72	-	191,414,476.72
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	511,201,648.27	943,092,871.27	2,092,083,042.29	-	3,546,377,561.83
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(191,414,476.72)	-	-	(191,414,476.72)
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
15	Тайлант үеийн үр дүн	-	-	(341,617,249.36)	-	(341,617,249.36)
16	ҮЛДЭГДЭЛ	511,201,648.27	751,678,394.55	1,750,465,792.93	-	3,013,345,835.75

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	940,483,884.00	878,842,685.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	940,483,884.00	878,842,685.00
1310	Улсын төсвөөс	875,918,400.00	828,866,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	875,918,400.00	828,866,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,755,084.00	7,184,985.00
131103	ЗГНХ,ЗДНХ,хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	2,349,600.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	19,330,484.00	4,295,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	75,000.00	2,889,985.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,810,400.00	42,791,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,810,400.00	42,791,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	940,483,884.00	878,842,685.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	940,483,884.00	878,842,685.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	842,311,671.96	840,671,288.72
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	695,032,738.00	671,893,906.00
210101	Үндсэн цалин	591,630,146.00	577,171,186.00
210104	Урамшуулал	57,969,881.00	48,551,020.00
210105	Гэрээт ажлын цалин	45,432,711.00	46,171,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,140,959.43	89,426,536.94
210201	Тэтгэврийн даатгал	66,566,760.43	63,237,825.00
210202	Тэтгэмжийн даатгал	522,065.00	6,930,802.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,515,331.00	5,250,175.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,319,035.00	1,244,799.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,217,768.00	12,762,935.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,320,599.53	37,317,030.78
210301	Гэрэл, цахилгаан	2,269,349.53	2,170,180.78
210302	Түлш, халаалт	21,051,250.00	35,146,850.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,191,940.00	9,353,085.00
210401	Бичиг хэрэг	1,274,950.00	2,404,485.00
210402	Тээвэр, шатахуун	3,358,630.00	2,154,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	275,000.00	445,000.00
210404	Ном, хэвлэл	5,169,800.00	2,645,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	493,360.00	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,620,200.00	1,204,500.00
2105	Нормативт зардал	20,539,935.00	25,452,530.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,370,000.00	2,220,000.00
210502	Хоол, хүнс	17,819,935.00	22,032,530.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,350,000.00	1,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	720,000.00	4,444,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,975,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	720,000.00	720,000.00
210604	Урсгал засвар	-	1,749,700.00
2107	Томилолт, зочны зардал	432,000.00	702,000.00
210702	Дотоод албан томилолт	432,000.00	702,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	843,500.00	1,466,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,466,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	47,500.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,090,000.00	615,500.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	2,090,000.00	615,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,172,212.04	38,171,396.28
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,489,800.47	3,724,769.22
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,489,800.47	3,724,769.22
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,490,780.57	10,172,387.06
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,490,780.57	10,172,387.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,191,631.00	24,274,240.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,653,767.00	18,013,440.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	15,910,284.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,627,580.00	6,260,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	-	-
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	-	-
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	-
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	871,657,700.0	871,657,700.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	871,657,700.0	871,657,700.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	846,469,700.0	833,486,303.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	674,748,800.0	671,893,906.00
210101	Үндсэн цалин	578,788,400.0	577,171,186.00
210104	Урамшуулал	49,788,700.0	48,551,020.00
210105	Гэрээт ажлын хөлс	46,171,700.0	46,171,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,578,400.0	89,426,536.94
210201	Тэтгэврийн даатгал	64,584,800.0	63,237,825.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,998,200.0	6,930,802.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,598,500.0	5,250,175.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,399,600.0	1,244,799.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,997,300.0	12,762,935.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,041,500.0	37,317,030.78
210301	Гэрэл, цахилгаан	2,424,900.0	2,170,180.78
210302	Түлш, халаалт	38,616,600.0	35,146,850.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,770,400.0	4,769,100.00
210401	Бичиг хэрэг	1,045,500.0	1,045,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,274,100.0	1,274,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	446,000.0	445,000.00
210404	Ном, хэвлэл	300,000.0	300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	500,000.0	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,204,800.0	1,204,500.00
2105	Нормативт зардал	28,551,400.0	25,452,530.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,220,000.0	2,220,000.00
210502	Хоол, хүнс	25,131,400.0	22,032,530.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,200,000.0	1,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,470,000.0	2,469,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	720,000.0	720,000.00
210604	Урсгал засвар	1,750,000.0	1,749,700.00
2107	Томилолт, зочны зардал	850,000.0	702,000.00
210702	Дотоод албан томилолт	850,000.0	702,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	840,000.0	840,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	840,000.0	840,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	619,200.0	615,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	619,200.0	615,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,188,000.00	38,171,396.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,188,000.0	24,274,240.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,888,000.0	18,013,440.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,300,000.0	6,260,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	-	3,724,769.22
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,724,769.22
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт,	-	10,172,387.06
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	10,172,387.06
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	871,657,700.0	871,657,700.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	871,657,700.0	828,866,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	42,791,500.0	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	828,866,200.0	828,866,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	42,791,500.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	42,791,500.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	7,184,985.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	7,184,985.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	7,184,985.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	4,583,985.00
210401	Бичиг хэрэг		1,358,985.00
210402	Тээвэр, шатахуун		880,000.00
210404	Ном, хэвлэл		2,345,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,975,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,975,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	626,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		626,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	7,184,985.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	7,184,985.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	-	4,295,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,889,985.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Бигэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Шилэн баланс аудит” ХХК-ний Говь-Алтай салбарын аудитор Б.Нямдорж гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Бигэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд суралцагчдын бие даан суралцах үйлийг дэмжин хоцрогдолгүй сургах, хөгжил төлөвшил, эрүүл аж төрөх хэв маяг, зөв дадалд суралцах

чадвар эзэмшүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж, хосолсон сургалтын орчин бүрдүүлэн ажиллах зорилго тавьсан. Улмаар зорилгоо биелүүлэхэд чиглэсэн 14 зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй. Харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бигэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 1,025.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 20.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 16.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын дүн болох 938.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 18.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 15.0 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бигэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10 хувиар буюу 342.6 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 53.8 сая төгрөгөөс 21.7 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, эм боох материал, түлш, шатах тослох материал, хүнсний материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 87.8 сая төгрөг, үнэ төлбөргүйгээр 9.6 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 75.7 сая төгрөгийн материалыг зарцуулж, Оны эцэст 75.5 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,518.9 сая төгрөгөөс 362.5 сая төгрөгөөр буурсан нь 1.9 сая төгрөгийн хөрөнгө авч, 25.1 сая төгрөгийн хөрөнгө хандиваар авч, ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийн үнэ шинэчлэн тогтоож 26.1 сая төгрөгөөр нэмэгдсэн. Аймгийн ИТХ-ын тогтоолоор 14.5 сая төгрөгийн тавилга, машин тоног төхөөрөмжийг акталж, 291.9 сая төгрөгийн барилга байгууламжийг ЗДТГ-т шилжүүлж данс бүртгэл зөрүүтэй бүртгэлд авсан 39.9 сая төгрөгийн хөрөнгийн сайжруулалт хийж залруулсан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,012.3 сая төгрөгөөс 3,325.9 сая төгрөгөөр буусан нь үлдэх өртөгтэй хөрөнгө шилжүүлсэн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү, тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 30 хувиар буюу 2,192.9 сая төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй авсан бараа материал, үндсэн хөрөнгө, орлого буурсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 3,012.3 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,111.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 239.9 сая төгрөгөөр бууруулж, 871.6 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 871.6 сая төгрөгийн төсөв баталснаас 828.8 сая төгрөгийг улсын төсвөөс 42.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 828.8 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 42.8 сая төгрөг, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны

төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөр 7.1 сая төгрөг нийт 878.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 862.4 сая төгрөгийг зарцуулж 6.2 сая төгрөгийг улсын төсөвт, 10.2 сая төгрөгийн орон нутгийн төсөвт тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 857.7.8 сая төгрөг буюу 98 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 2.8 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 3.1 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3.7 сая төгрөгөөр, нормативд зардлыг 3.1 сая төгрөгөөр, албан томилолтын зардлыг 0.1 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 7.1 сая төгрөгийн гүйлгээ хийгдэн, 4.5 сая төгрөгийг хангамж, бараа материалын зардал, 1.9 сая төгрөгийг багаж техник хэрэгсэл, үндсэн хөрөнгө бэлтгэж, 0.6 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим сайтад мэдээллийг байршуулсан байх 917.1 сая төгрөгийн 18 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим системд ил тод байршуулахаас 56.4 сая төгрөгийн 4 мэдээллийг ил тод байршуулаагүй байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж

мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,6 сая төгрөгийн төлбөрийн акт, 12.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн байна.

3.11 Дараагийн жилийн аудитаар

- Шилэн дансны мэдээллийг бэлтгэх хугацаандаа үнэн зөв байршуулсан эсэх,
- И-баримтын бүрдэл хангалтгүй төрийн сангаар гүйлгээ хийсэн
- Цалин хөлс нэмэгдэл урамшуулал тооцох
- Бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах
- Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 43.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 40.9 сая төгрөгийн алдааг залруулж, 1.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад 2020 онд ашиглалтад орсон шинэ барилгын зураг төсвийг бусад биет бус хөрөнгөнд бүртгэсэн байсныг барилгын төсөвт өртгийг нэмэгдүүлж залруулсан.

Үнэ төлбөргүй хүлээн авсан материалыг бараа материалын дансанд үнэ тогтоон авсан ба зөрүү 1.0 сая төгрөгийг бүртгэн залруулав.

4.2 Төлбөрийн акт

Ажилтанд үр дүнгийн урамшууллыг тушаал шийдвэргүйгээр 0.4 сая төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно" заалттай нийцэхгүй, зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Шуудан холбооны зардлаас багш нарт тушаал шийдвэргүйгээр 0.15 сая төгрөгийн нэгж олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5."Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалт "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалттай нийцэхгүй, бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Сургуулийн зөвлөлийг 0.45 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 тоот тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга

хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалт “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” заалттай нийцэхгүй, бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Тайлант онд 1.1 сая төгрөгийн И-баримтгүй худалдан авалт хийсэн, төрийн сан хяналт тавиагүй байгаа нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."-д оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Батлагдсан төсөвт зардлыг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалт “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”-д оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар шилэн дансны тухай хуулийг хэрэгжилтийг хангуулах 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс 142 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон 5 мэдээлэл, мэдээлэлгүй 2 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. 2021 оны 917.1 сая төгрөгийн 18 мэдээллийг ил тод байршуулахаас 56.4 сая төгрөгийн 3 мэдээллийг ил тод байршуулаагүй, 826.8 сая төгрөгийн 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" Шилэн дансны тухай хуулийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8-т "Бонд, зээл, ерийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг мөрдөн ажиллах

2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бигэр сумын Ерөнхий боловсролын сургууль	8	43.0	2	40.9	3	1.0	2	1.1	1	
	Дүн	8	43.0	2	40.9	3	1.0	2	1.1	2	